

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН
2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/144/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 70432545 цахим хаяг: ErdenetsetsegD@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
АОУС	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
УСНББОУС	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
ТТЗ	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
ТШЗ	<i>Төсвийн шууд захирагч</i>
ЕБС	<i>Ерөнхий боловсролын сургууль</i>
НДШ	<i>Нийгмийн даатгалын шимтгэл</i>
ХАОАТ	<i>Хүн амын орлогын албан татвар</i>
ЗДТГ	<i>Засаг даргын тамгын газар</i>
СТСХ	<i>Санхүү, Төрийн сангийн хэлтэс</i>
БШУЯ	<i>Боловсрол шинжлэх ухааны яам</i>

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	15
4. Менежментийн захидал	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

1.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цэнцэглэвч Бүг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.25 № 2/134
танай _____-ны № _____-т

БУЛГАН СУМЫН 2-Р СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.СОНГУУЛЬ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын 2-р сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Булган сумын 2-р сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургалтын чанар, элсэлтийн шалгалтын бодит байдал /суралцагчийн сурлагын түвшин, суралцагчийн сурах ээлтэй орчин бүрдүүлсэн / зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг/ агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангаар төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт бодит бус, хүүхдийн хоолны талон батлуулаагүй хүнс зарлагдсан, тусгай зөвшөөрөлгүй газраас эм эмийн хэрэгсэл худалдан авсан, үдийн цай нийлүүлсэн аж ахуйн нэгжийн гэрээ дүгнээгүй, анхан шатны баримт байхгүй, хүнсний муудах материал болон нүүрс их хэмжээгээр нөөцөлсөн, хөрөнгийн тооллого хийгээгүй, нүүрс хэтрүүлэн зарцуулсан, нийгмийн даатгалын шимтгэл төсвөөс илүү төлсөн, өмнөх оны авлага бууруулаагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, хөрөнгийн зардалд тавих дотоод хяналт сул зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр

020530

ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "оршин байх", "толилуулаа ба тодруулаа", "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОРДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>78,355,729.68</u>	<u>93,763,344.68</u>
33	АВЛАГА	2,999,353.40	2,940,707.40
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,999,353.40	2,940,707.40
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>75,356,376.28</u>	<u>90,822,637.28</u>
351	Түүхий эд материал	5,345,534.00	10,285,984.00
35110	Тусгай зориулалттай материал	5,345,534.00	6,174,534.00
35130	Эм боох материал	00.00	4,111,450.00
354	Хангамжийн материал	70,010,842.28	80,536,653.28
35410	Бичиг хэргийн материал	28,193,480.00	22,245,216.00
35420	Аж ахуйн материал	8,462,900.00	7,766,000.00
35440	Түлш, шатах тослох материал	11,963,518.78	33,358,523.78
35450	Барилгын засварын материал	750,750.00	750,750.00
35460	Хүнсний материал	20,640,193.50	16,416,163.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,063,854,497.09</u>	<u>1,984,183,464.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,063,854,497.09	1,984,183,464.27
392	Биет хөрөнгө	1,959,187,097.09	1,879,516,064.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,828,167,461.00	1,828,167,461.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-136,591,440.92	-253,811,007.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	26,000,000.00	26,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17,333,332.97	-21,666,666.29
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	277,965,445.00	322,908,809.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	-240,988,199.76	-249,782,925.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	310,384,045.00	322,459,805.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-128,210,783.08	-138,889,683.04
39217	Ном	39,793,902.82	44,130,270.82
393	Биет бус хөрөнгө	104,667,400.00	104,667,400.00
39301	Програм хангамж	330,000.00	330,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	104,612,400.00	104,612,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-275,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,142,210,226.77</u>	<u>2,077,946,808.95</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,302,662.78</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,302,662.78	00.00
413	Өглөг	1,302,662.78	00.00
4136	Бусад өглөг	1,302,662.78	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,302,662.78	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,140,907,563.99</u>	<u>2,077,946,808.95</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,140,907,563.99	2,077,946,808.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,937,494,876.00	1,937,494,876.00
51101	Өмч: - төрийн	1,937,494,876.00	1,937,494,876.00

512	Хуримтлагдсан үр дүн	-1,002,922,286.70	-1,065,883,041.74
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,002,922,286.70	-1,002,922,286.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-62,960,755.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,206,334,974.69	1,206,334,974.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,142,210,226.77	2,077,946,808.95

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,482,612,997.00	1,796,969,100.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	82,598,700.58
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	82,598,700.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	82,598,700.58
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,350,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	81,248,700.58
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	93,805,297.00	1,714,370,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	80,000.00	1,621,140,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,388,807,700.00	1,621,140,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	81,111,400.00	93,230,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,111,400.00	93,230,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,636,072,010.69	1,839,721,647.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,636,072,010.69	1,839,721,647.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,571,523,678.89	1,697,089,079.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,107,680,751.20	1,272,648,348.55
210101	Үндсэн цалин	1,104,517,351.20	1,246,726,986.55
210104	Урамшуулал	1,739,600.00	25,921,362.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,175,334.00	159,201,549.00
210201	Тэтгэврийн даатгал	136,175,334.00	159,201,549.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,661,588.20	72,292,995.00
210301	Гэрэл, цахилгаан	13,388,211.00	14,097,990.00
210302	Түлш, халаалт	61,035,605.00	58,195,005.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,814,189.00	21,834,401.25
210401	Бичиг хэрэг	3,359,950.00	9,657,460.00
210402	Тээвэр, шатахуун	9,609,630.00	1,749,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,645,209.00	1,891,084.00
210404	Ном, хэвлэл	543,000.00	1,729,868.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,390,700.00	6,806,988.89
2105	Нормативт зардал	88,259,775.50	30,828,780.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	204,500.00	3,478,050.00
210502	Хоол, хүнс	85,653,075.50	27,350,730.00
2107	Томилолт, зочны зардал	585,100.00	585,100.00
210702	Дотоод албан томилолт	585,100.00	585,100.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	282,750.00	1,400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	282,750.00	1,400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,551,690.99	147,309,144.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	310,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,210,300.00	5,972,193.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	140,341,390.99	141,026,525.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,548,331.80	133,621,329.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,548,979.10	27,735,300.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	10,610,117.00	0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,704,800.00	27,735,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,999,352.70	105,886,029.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,999,352.70	105,886,029.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-153,459,013.69</u>	<u>-42,752,547.04</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	-20,208,208.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	-20,208,208.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	20,208,208.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-153,459,013.69</u>	<u>-62,960,755.04</u>

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	800,281,782.10	1,715,720,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,350,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,350,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,350,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,350,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	800,281,782.10	1,714,370,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,621,140,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	795,017,372.10	1,621,140,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	560,000.00	93,230,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	93,230,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	800,281,782.10	1,715,720,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	800,281,782.10	1,715,720,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	769,760,310.00	1,576,893,451.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	588,001,543.00	1,161,503,369.52
210101	Үндсэн цалин	502,081,639.00	1,109,680,769.52
210102	Нэмэгдэл	40,640,318.00	22,786,900.00
210104	Урамшуулал	19,845,700.00	29,035,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,304,094.00	262,258,823.00
210201	Тэтгэврийн даатгал	128,304,094.00	262,258,823.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,030,318.00	92,580,200.00
210301	Гэрэл, цахилгаан	7,022,654.00	14,097,990.00
210302	Түлш, халаалт	6,700,740.00	78,482,210.00

2104	Хангамж, бараа материалын зардал	5,858,815.00	11,558,480.00
210401	Бичиг хэрэг	837,640.00	4,866,196.00
210402	Тээвэр, шатахуун	2,185,075.00	3,206,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	907,500.00	1,891,084.00
210404	Ном, хэвлэл	289,000.00	802,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,492,800.00	792,000.00
2105	Нормативт зардал	28,774,880.00	31,847,314.06
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	8,104,614.06
210502	Хоол, хүнс	28,774,880.00	20,399,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	3,343,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	781,400.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	781,400.00
2107	Томилолт, зочны зардал	333,900.00	585,100.00
210702	Дотоод албан томилолт	333,900.00	585,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	10,999,427.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,400,000.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	00.00	9,599,427.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,456,760.00	4,779,338.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	782,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,456,760.00	3,996,638.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,521,472.10	138,826,948.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,521,472.10	32,940,919.32
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,704,410.00	4,505,619.32
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,583,000.00	28,435,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	105,886,029.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	105,886,029.10
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,937,494,876.00	1,206,334,974.69	(850,211,273.01)	2,293,618,577.68
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,937,494,876.00	1,206,334,974.69	(850,211,273.01)	2,293,618,577.68
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(153,459,013.69)	(153,459,013.69)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,937,494,876.00	1,206,334,974.69	(1,002,922,286.70)	2,140,907,563.99
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,937,494,876.00	1,206,334,974.69	(1,002,922,286.70)	2,140,907,563.99
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,937,494,876.00	1,206,334,974.69	(1,002,922,286.70)	2,140,907,563.99
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(62,960,755.04)	(62,960,755.04)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,937,494,876.00	1,206,334,974.69	(1,065,883,041.74)	2,077,946,808.95

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	464,816,100.00	1,609,834,370.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	464,816,100.00	1,609,834,370.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,733,300.00	1,576,893,451.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	322,775,900.00	1,161,503,369.52
210101	Үндсэн цалин	221,224,200.00	1,109,680,769.52
210102	Нэмэгдэл	72,516,000.00	22,786,900.00
210104	Урамшуулал	29,035,700.00	29,035,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,574,900.00	262,258,823.00
210201	Тэтгэврийн даатгал	30,663,600.00	262,258,823.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,227,900.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,582,200.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	645,800.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,455,400.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,974,500.00	92,580,200.00
210301	Гэрэл, цахилгаан	2,170,500.00	14,097,990.00
210302	Түлш, халаалт	30,354,000.00	78,482,210.00
210303	Цэвэр, бохир ус	450,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,297,100.00	11,558,480.00
210401	Бичиг хэрэг	246,300.00	4,866,196.00
210402	Тээвэр, шатахуун	874,500.00	3,206,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	273,300.00	1,891,084.00
210404	Ном, хэвлэл	218,700.00	802,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	118,500.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	565,800.00	792,000.00
2105	Нормативт зардал	36,049,500.00	28,427,283.73
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,900.00	8,104,614.03
210502	Хоол, хүнс	35,177,700.00	16,979,369.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	720,900.00	3,343,300.00
2107	Томилолт, зочны зардал	159,600.00	585,100.00
210702	Дотоод албан томилолт	159,600.00	585,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	392,000.00	1,400,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	392,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2509800.00	8199368.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	368,100.00	4,202,730.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,141,700.00	3,996,638.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24082800.00	32940919.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,082,800.00	32,940,919.32
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,082,800.00	28,435,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	896,289,500.00	1,609,834,370.90
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	862,947,000.00	1,515,254,170.90

131001	Улсын төсвөөс санхүүжих	431,473,500.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	431,473,500.00	1,515,254,170.90
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,974,500.00	93,230,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	32,974,500.00	93,230,200.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	368,000.00	1,350,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	368,000.00	1,350,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	114.00	114.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	65.00	65.00
620003	Үйлчлэх ажилтан	35.00	35.00
620004	Гэрээт ажилтан	13.00	13.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Нэмэлт дансаар гүйлгээ хийгээгүй байна.

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Булган сумын ЕБ-ийн 2-р сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Ц.Сонгууль танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагын тогтмол зардал, эмийн зардал, хоол хүнсний зарцуулалтын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 20-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт чанарыг сайжруулах, багшийн мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилго дэвшүүлэн ажиллажээ. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь:

- ✓ Ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага
- ✓ Эх хэлний чадварыг хөгжүүлэх
- ✓ Боловсролын үйлчилгээнд хүн бүр оролцогч байх чадамжийг дээшлүүлэх
- ✓ Суралцах чадвар, сургалтын чанарт ахиц гаргах
- ✓ Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлнэ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Булган сумын ЕБ-ийн 2-р сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг БШУЯ-наас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор БСУГ-ын дотоод хяналт болон бусад хяналтын байгууллагууд 2020 онд тус байгууллагад хяналт хэрэгжүүлээгүй боловч сумын Төрийн сангаас өдөр тутмын санхүүгийн гүйлгээнд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй байна.

Булган сумын ЕБ-ийн 2-р сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 1640203.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 16402.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 1819513.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 18195.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган сумын ЕБ-ийн 2-р сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 64263.5 мянган төгрөгөөр буюу 9.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	2,999.3	2,940.7	-58.6
БАРАА МАТЕРИАЛ	75,356.4	90,822.6	15,466.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,063,854.6	1,984,183.5	-79,671.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,142,210.3	2,077,946.8	-64,263.5
БОГИНО ХУГАЦААТ ӨР	1,302.7	0.0	-1,302.7
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН	2,140,907.6	2,077,946.8	-62,960.8
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР	2,142,210.3	2,077,946.8	-64,263.5

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 2940.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Аж ахуйн нэгж байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг барагдуулсан байна. Өмнөх оны насжилт өндөртэй авлага бууруулаагүй, ажилчидтай холбогдох шимтгэлийн тооцоог илүү төлөөд авлагаар тусгаагүй, цалинтай холбоотой тооцоог татвар, даатгалын байгууллагатай тооцоо хийж тооцоо нийлсэн актаар авлагагүй гэж хоорондын тооцоог баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 90822.6 мянган төгрөг болж 15466.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хичээл ороогүйтэй холбоотой шинээр бараа материал бага авч үлдэгдэл материалаа зарцуулсан байгаа нь нөлөөлж байна. Бараа материалын зардлаас хүнсний материал оны эхэнд үлдэгдэл ихтэй байсан мөн оны эцэст махны үлдэгдэл ихтэй байгаа нь махны хадгалалтад нөлөөлөх эрсдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 2063854.6 мянган төгрөг, оны эцэст 1984183.5 мянган төгрөг болж 79671.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант онд төсвийн хөрөнгөөр төсвийн хөрөнгөөр 315.0 мянган төгрөгийн ном, БСУГ-аас 74258.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Булган сумын ЗДТГ-аас 1989.7 мянган төгрөгийн хүүхдийн ширээ сандал, ОНХС-аас 5000.0 мянган төгрөгийн ширээ сандал, тоног төхөөрөмж, сурах бичиг 2020,12,30-ны 71 тоот ИТХ-ын тогтоолоор үнэ төлбөргүй орлогоор авч, 20208.2 мянган төгрөгийн ном сумын ИТХ-ын 2021.01.06-ны 03 тоот тогтоолоор акталж данснаас хасалт хийж тайлагнасан байна. Тайлант онд бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй байна.

Өр төлбөр оны эхэнд 1302.6 мянган төгрөгийн аж ахуйн нэгжтэй холбогдсон өглөгтэй байснаас тайлант онд 1302.6 мянган төгрөгийн өрийг бүрэн барагдуулсан бөгөөд тайлант оны эцэст өрийн үлдэгдэлгүй байна. Тайлант онд өмнөх оны өр төлсөн гэж материалын зардал төлсөн байгаа нь хоорондын тооцоо хийгээгүй, санхүүгийн тайлангаар тайлагнаагүй байгаатай холбоотой зөрчил байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл оны эцэст 2077946.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Оны эхнээс 62960.8 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүнгээр буурсан байна.

Булган сумын ЕБ-ийн 2-р сургуулийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 314356.2 мянган төгрөгөөр буюу 43.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 314356.2 мянган төгрөгийн орлогын өөрчлөлтөөс тусгай зориулалтын санхүүжилт 314356.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 203649.6 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн зардал 164967.6 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 38682.0 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бодлогын өөрчлөлтөөр бүртгэлийн бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1876532.5 мянган төгрөгөөр нийт зарлагыг 1876532.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд тусгай зориулалтын шилжүүлгээс 1716269.3 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 96929.2 мянган төгрөгөөр туслах үйл ажиллагааны орлогыг 1350.0 мянган төгрөгөөр нийт үйл ажиллагааны зардлыг 1814548.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1814548.5 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 1716269.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 96929.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1350.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1714370.4 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 1621140.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 93230.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1350.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 1609834.4 мянган төгрөг зарцуулж 105886.0 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гарган төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1609834.4 мянган төгрөг буюу 85% зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрөөс хэмнэлт гаргасан байна.

Хөтөлбөр арга хэмжээний хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	314.8
81801	Үндсэн үйл ажиллагааны зардал	10,199.9
81806	Хоол хүнс	35,378.7
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	59,992.6
ДҮН		105,886.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар орлого оруулж зарцуулаагүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 134 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 114, мэдээллийг огт оруулаагүй 6, мэдээлэл дутуу оруулсан 14 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 6 мэдээллийг байршуулаагүй байгааг залруулан мэдээллийг оруулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Булган сумын 2-р сургуульд 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөвлөмжийг өгсөн байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	1	13,307.8	-	-	1	13,307.8	-
Нийт дүн	1	13,307.8	-	-	1	13,307.8	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар 229132.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 154558.2 мянган төгрөгийн алдаа залруулж 74574.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчлөөс 5037.9 мянган төгрөгийн 4 зөрчилд 2 төлбөрийн акт, 63816.1 мянган төгрөгийн 4 зөрчилд 1 албан шаардлага, 5720.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ.

Залруулсан алдаа: Аудитаар тайлангийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлд 110201.2 мянган төгрөгийн санхүүжилт дутуу илэрхийлсэн, үр дүнгийн тайланд дахин үнэлгээний хорогдол гэж буруу бичилт хийсэн 44357.0 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 5037.9 мянган төгрөгийн 4 зөрчилд 2 төлбөрийн акт, 63816.1 мянган төгрөгийн 4 зөрчилд 1 албан шаардлага бичлээ.

1. Авлага

1.1. **Илрүүлэлт:** Цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэл илүү төлж авлагаар тусгаагүй, цалингийн карт хөтлөөгүй, гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй, тооцоо нийлсэн актаар авлагагүй гэж хоорондын тооцоо нийлсэн 1618.8 мянган төгрөг,

1.2. **Илрүүлэлт:** Цалингийн ашиг өмнөх онд илүү төлж авлагаар тусгасан ч тайлант онд авлага бууруулаагүй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, цалингийн зардал тайланд бодитоор илэрхийлэгдээгүй, тооцоо нийлсэн актаар авлага байхгүй гэж тооцоо хийсэн 2833.4 мянган төгрөг,

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Мөнгөн хөрөнгө

- 2.1. Илрүүлэлт: Хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэж байгаа дэлгүүрийн боорцог, гоймон, талх шинжилгээний бичиггүй, хүнс нийлүүлэх гэрээ байхгүй, мах, сүү нь гарал үүслийн бичиггүй, хүүхдийн хоолны талон батлуулаагүй хоол зарлагдсан 385.0 мянган төгрөг,
- 2.2. Үдийн цай нийлүүлж байгаа аж ахуйн нэгж сургуулийн байр түрээслээд түрээсийн төлбөрөө дутуу төлсөн, цахилгаан бусад зардлыг тооцсон тооцоо байхгүй 200.0 мянган төгрөгийн алдаа зөрчил тус тус илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. Бараа материал

- 3.1. Илрүүлэлт: Бараа материалын зардал шилжүүлэхдээ е баримтгүй гүйлгээ хийсэн, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, шууд зардлаар бүтээсэн 15901.5 мянган төгрөг,
- 3.2. Илрүүлэлт: Нүүрсний тооцоо хийж зарцуулалтыг хянаагүй, норм нормативаас их хэмжээгээр хэтрүүлэн зарцуулсан, е баримтгүй гүйлгээ хийсэн, нүүрс худалдаж авч их хэмжээгээр нөөцөлсөн 18850.0 мянган төгрөг,
- 3.3. Илрүүлэлт: Үдийн цай нийлүүлж байгаа аж ахуйн нэгжтэй хийсэн гэрээ байхгүй, хүүхдийн ирц бүртгэсэн хуудас засвартай, анхан шатны баримт байхгүй 27672.3 мянган төгрөг,
- 3.4. Илрүүлэлт: Хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэж байгаа дэлгүүрийн боорцог, гоймон, талх шинжилгээний бичиггүй, хүнс нийлүүлэх гэрээ байхгүй, мах, сүү нь гарал үүслийн бичиггүй, хүүхдийн хоолны талон батлуулаагүй хоол зарлагдсан 1392.3 мянган төгрөгийн зөрчил тус тус илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага бичих

Аудитын зөвлөмж: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 5720.4 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар бараа материалын зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт :

- 4.1. Илрүүлэлт: Цахилгааны төлбөр нэхэмжилсэн дүнгээс илүү төлөөд авлагаар бүртгээгүй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй 661.9 мянган төгрөг,

Илрүүлэлт: Хөрөнгө материалын тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, акталсан ном устгасан дүгнэлтгүй, төсвийн хөрөнгөөр ном худалдаж аваад данс бүртгэлд тусгаагүй шууд зардалд бүртгэсэн 806.0 мянган төгрөг зэрэг зөрчил илэрлээ.

- 4.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, байх дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж хангагдахгүй байх
- 4.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж е-баримтын хэрэгжилтийг хангаж ажиллах,
- 4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

5. Бараа материал

- 5.1. Илрүүлэлт: Эм эмийн хэрэгслийг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс гэрээ хийж ариутгалын бодис аваагүй 3574.5 мянган төгрөг,
- Илрүүлэлт: Хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэж байгаа дэлгүүрийн боорцог, гоймон, талх шинжилгээний бичиггүй, хүнс нийлүүлэх гэрээ байхгүй, мах, сүү нь гарал үүслийн бичиггүй, хүүхдийн хоолны талон батлуулаагүй хоол зарлагдсан 1392.3 мянган төгрөг зэрэг зөрчил илэрлээ.
- 5.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, байх дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж хангагдахгүй байх
- 5.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж е-баримтын хэрэгжилтийг хангаж ажиллах,
- 5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Булган сумын ЕБ-ийн 2-р сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/144/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган сумын ЕБ-ийн 2-р сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэл илүү төлж авлагаар тусгаагүй, цалингийн карт хөтлөөгүй, гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй, авлага бууруулаагүй	4452.3	Төлбөрийн акт	Булган сумын ЕБ-ийн 2-р сургуулийн захирал, Нягтлан бодогч	Ц.Сонгууль Г.Ганбаяр
3	Үдийн цай нийлүүлж байгаа аж ахуйн нэгж сургуулийн байр түрээслээд түрээсийн төлбөрөө дутуу төлсөн, цахилгаан бусад зардлыг тооцсон тооцоо байхгүй, хоолны талон засварласан, хүнсний нийлүүлсэн аж ахуйн нэгжийн гэрээ дүгнээгүй	585.6	Төлбөрийн акт		
5	Бараа материалын зардал шилжүүлэхдээ е баримтгүй гүйлгээ хийсэн, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нүүрс хэтрүүлэн зарцуулсан, үдийн цайны хүүхэд өдөр засвартай, хүүхдийн хоолны талон засвартай	63816.9	Албан шаардлага		
9	Хөрөнгө материалын тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, акталсан ном устгасан дүгнэлтгүй, төсвийн хөрөнгөөр ном худалдаж аваад данс бүртгэлд тусгаагүй шууд зардалд бүртгэсэн, илүү мөнгө шилжүүлээд авлага тусгаагүй	1467.9	Зөвлөмж		
11	Эм эмийн хэрэгслийг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс гэрээ хийж ариутгалын бодис аваагүй	3574.5	Зөвлөмж		
12	Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилт дутуу тайлагнасан, төсвийн гүйцэтгэл буруу илэрхийлсэн,	110201.2	Залруулга хийсэн		

13	Үндсэн хөрөнгийн тайланд дахин үнэлгээний хорогдол гэж дахин үнэлгээтэй хөрөнгө актлаагүй байхад данснаас хасалт хийж үр дүнгийн тайланд тусгасан, акталсан ном үнэ төлбөргүй зардлаар бүртгэсэн	44357.0	Залруулга хийсэн		
ДҮН		229132.7			

ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР